



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/210

Өмнөдэлгэр сум

Асран хамгаалагч түр тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.2, 65.1.3, 65.1.4, 65.1.5 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1.5 дахь заалт, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт, 73 дугаар зүйлийн 73.2.3 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн иргэн Хэрээд овогт Жигжидсүрэнгийн Цолмон нь 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр нас барсан. Түүний хүүхдүүд болох Цолмонгийн Нямсамбуу, Цолмонгийн Шинэбаяр, Цолмонгийн Тодбаяр нарыг төрсөн эгч Гантулгын Ганбаяр асран хамгаалж байгаа бөгөөд хүүхдүүд болон Г.Ганбаярын хүсэлтийг үндэслэн Ц.Нямсамбуу, Ц.Шинэбаяр, Ц.Тодбаяр нарын асран хамгаалагчаар Өмнөдэлгэр сумын Талын булаг багийн иргэн Гантулгын Ганбаярыг түр тогтоосугай.

2. Г.Ганбаяр нь Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд заасан асран хамгаалагчийн үүргийн дагуу жил бүр сумын Засаг дарга болон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд тайланг бичгээр гарган өгөхийг үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР

D:\disk\bichig hereg/ zahiramj/

2326310422